

БАТЛАВ
 ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН
 СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН
 НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.Төмөрхүү С.ТӨМӨРХҮҮ

**ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСӨЛД
 АВАХ “ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**

2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр

№ 2024/07

Улаанбаатар хот

Захиалагч байгууллага:	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
Хариуцах нэгж, хэлтэс	Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газар; Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газар; Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтэс.
Байршил:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай-3
Зөвлөх үйлчилгээний үндэслэл, хэрэгцээ шаардлага	<p>Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9.2-т "Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот бий болгоно" гэж, 9.4-т "Хууль, эрх зүйн тогтвортой орчинтой, хотын дүрэм, стандартыг хангуулсан сайн засаглалтай хот бий болгоно" гэж, мөн шинээр байгуулагдсан хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрт "Хот байгуулалтын болон Газрын багц хуулийг шинэчлэн баталж, хот төлөвлөлтийн дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана" зэрэг томоохон зорилтуудыг тус тус дэвшүүлсэн.</p> <p>УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1-д "Улаанбаатар хот-"20 минутын хот" стандарт", 1.1.1-д "Хот төлөвлөлт, засаглалын шинэчлэл" хийнэ,", 4.2.4.3-т "Хот байгуулалт, барилга, газрын талаарх холбогдох хуулийн уялдааг сайжруулж, төлөвлөлтөд суурилсан хот байгуулалтын тогтолцоог бий болгон, хотын ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн төлөвлөгөөний дагуу газрын зөвшөөрлийг олгож, зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлагыг чангатгана." гэж тусгасан.</p>
Ажлын даалгаврын нэр	Хот байгуулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөлд авах зөвлөх үйлчилгээ
Ажлын зорилго, зорилт:	Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд 25.1.4-д "тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон" тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна гэж заасны дагуу Монгол Улсын хот байгуулалтын бодлогын хүрээнд хүн амын нутагшилт, суурьшил болон харьцангуй бие даан хөгжих бүс нутгийн хөгжлийн зохистой бүтэц бүрдүүлэх, хот, тосгоныг хот төлөвлөлтийн дагуу барьж байгуулахад төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хооронд үүсэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн уялдаа холбоог

	сайжруулах, давхардал хийдлийг арилгах зорилгоор Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, тус хуулийг дагалдах хуулийн төслүүдийг боловсруулах болон Засгийн газар, УИХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх, батлуулах үйл ажиллагаанд туслан, зөвлөхөд энэхүү үйлчилгээний ажлын зорилго оршино.
Зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ажил:	<p>Судалгааны ажлын хүрээнд дараах ажлын үр дүнг хүлээн авна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчлэн боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах; 2. Дэлхийн улс орнуудын хот төлөвлөлт болон хот байгуулалтын хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа /15 минутын хотын үзэл баримтлал/; 3. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, батлуулах; 4. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах; 5. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай, Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай, Хот суурин газрыг лахин хөгжүүлэх тухай, Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулиуд болон бусад холбогдох хуулиуд, УИХ, Засгийн газраас гарсан тогтоол, шийдвэрүүдийн уялдаа холбоог шалгаж, дагалдах хуулийн төслүүдийг боловсруулах 6. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх судалгаа; 7. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо; 8. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах, саналыг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, төсөлд саналыг тусгах.
Арга зүй:	<ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль; 2. Хууль тогтоомжийн тухай хууль; 3. Хуулийн төсөл болон бодлогын судалгааны нийтлэг бусад арга зүйг ашиглах.
Даалгаврын хугацаа:	90 хоног
Багийн бүтэц, бүрэлдэхүүн:	<ol style="list-style-type: none"> 1. Судлаач, эрх зүйчдээс бүрдсэн 2-оос дээш гишүүнтэй баг бүхий хууль тогтоомжийн төслийн үр нөлөө, хэрэгжилтийн үр дагаварыг судлах, эрх зүй, нийгэм, эдийн засгийн судалгаа хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байх (Төрийн бус байгууллага буюу компани).
Тавигдах шаардлага болон ажлын туршлага	<ol style="list-style-type: none"> 1. Багийн ахлагч, гишүүдэд дараах шаардлагыг хангасан байна: <ol style="list-style-type: none"> a. Багийн ахлагч эрх зүй буюу нийгмийн ухааны удирдлагын чиглэлээр чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй байх; b. Ажлын хэсгийн гишүүд эрх зүй, хот байгуулалт, барилга угсралтын инженер, нийгмийн ухаан, архитектор, социологи, эдийн засгийн аль нэг чиглэлээр бакалавр, түүнээс дээш зэрэгтэй байх; c. Багийн нэгээс доошгүй гишүүн хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай бийх.

	<p>d. Хариуцсан ажлаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэх, богино хугацаанд ачаалалтай ажиллах, удирдан зохион байгуулах чадвартай байх</p> <p>2. Дараах шаардлагыг хангасан бол давуу тал болно.</p> <p>a. Багийн гишүүдийн гуравны хоёр нь хуульч, гуравны нэг нь архитектор, хот төлөвлөгч байвал давуу тал болно.</p> <p>b. Баг буюу гишүүдийн өмнө хийсэн судалгааны ажил, эрдэм шинжилгээний бүтээл, боловсруулсан хууль тогтоомжийн төслийн жагсаалтыг хавсаргах;</p> <p>c. Багийн 1-ээс доошгүй гишүүн нь Англи зэрэг нийтлэг гадаад хэлээр Гадаад улсын хуулийн харьцуулсан судалгаа хийх чадвартай байх, энэ чиглэлээр хийсэн ажлын туршлагатай байх.</p>
<p>Судалгааны ажлын тайлангийн үе шат, ажлын үр дүн</p>	<p>Эхлэлтийн тайлан: Гэрээ байгуулснаас хойш ажлын 3 хоногийн дотор эхлэлтийн тайланг Захилагчид хүлээлгэн өгнө. Эхлэлтийн тайланд Судалгааны тайлангийн ерөнхий загвар, мэдээллийг нэгтгэх, цуглуулах, боловсруулах аргачлалыг тодорхойлж, ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан ирүүлсэн байна.</p> <p>Дунд хугацааны тайлан: Гэрээ байгуулснаас хойш 40 хоногийн дотор ажлын үр дүнгийн бүрдэл 1, 2-ыг холбогдох тайлангийн хамт Захиалагчид хүлээлгэн өгөх.</p> <p>Эцсийн тайлан: Гэрээ байгуулснаас хойш 90 хоногийн дотор холбогдох эцсийн тайлангуудаа хүлээлгэн өгнө.</p>
	<p>Ажлын үр дүн: Бүрдэл-1:</p> <ul style="list-style-type: none"> - Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон урьдчилсан тандан судалгаа; - Олон улсын харьцуулсан судалгаа; - Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ; - Зардлын тооцооны судалгаа; - SWOT болон Pestle шинжилгээ. <p>Бүрдэл-2:</p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл; - Танилцуулга, Power Point хувилбарын хамт. <p>Бүрдэл-3:</p> <ul style="list-style-type: none"> - Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл; - Товч, дэлгэрэнгүй танилцуулга, Power Point хувилбарын хамт. <p>Бүрдэл-4: Бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт, тэдгээрийг дагаж гарах шийдвэрийн төслүүд.</p>
<p>Ажлын зохион байгуулалт болон үр дүнг тайлагнах:</p>	<ol style="list-style-type: none"> 1. Судалгааны баг тус ажлын ерөнхий зорилго болон хүрээг өөрчлөхгүйгээр харилцан зөвшилцсөний үндсэн дээр Ажлын даалгаварт өөрчлөлт оруулж болно. 2. Судалгааны баг нь Төрийн нарийн бичгийн даргатай гэрээ байгуулж ажиппана 3. Судалгааны баг нь дүн шинжилгээ хийх үе шат, арга хэмжээг сонгох, тодорхойлох, томъёолохдоо тус яамны Ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн даргатай зөвшилцөнө.

	<p>4. Судалгааны баг Ажлын хэсэгт ажлаа тайлагнаж, хүлээлгэн өгөх бөгөөд цахим хувилбарыг хавсаргана.</p> <p>5. Судалгааны баг нь ажлын хэсгийн дарга, гишүүдтэй зөвлөх үйлчилгээний ажлын чиглэлээр тухай бүр харилцаж, уулзалт, ярилцлага хийх болон шаардлагатай мэдээ, мэдээлэл, тоо, баримт, судалгаа, тайланг, дүгнэлт, зөвлөмжийг авна.</p>
<p>Төлбөрийн нөхцөл:</p>	<p>Ажлын хөлсийг төлбөрийн стандарт арга буюу ажлын үр дүнд үндэслэсэн хэлбэрээр буюу эхлэлт, дундын болон эцсийн тайлан хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор гэрээнд заасны дагуу ажлын даалгаврын гүйцэтгэлээр хэсэгчлэн төлнө.</p> <p>Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд холбогдох бүх зардал, татвар зэрэг багтсан байна.</p>

---o0o---